



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 776

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 5,350,039,296.00 (таван тэрбум гурван зуун тавин сая гучин есөн мянга хоёр зуун ерэн зургаа) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Баян-Өлгий, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бурийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, эзэмшигчийг тогтоож бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Дугаар

Д.НАРАНГЭРЭЛ  
132003?07  
32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 12 дугаар сарын 20-ны/ний өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРСАН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ**

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэээрх хөрөнгийн дүн (төгрөг)		Улсын комиссын акт	Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
			Огноо	Дугаар		
1	Хэntий аймгийн Биндэр сумын эмнэлгийн болон эмчийн барилга (Хэntий аймгийн Биндэр сумын Эрүүл мэндийн төв, өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 20 ортой барилга, дунд төвөгшилтэй, хагас зоорийн давхар нь тэнхлэгээрээ 17.0*12.0м, дээш 2 давхар, тэнхлэгээрээ 53.6*12.0м, эмчийн барилга тэнхлэгээрээ 9.0*6.0м, 1 давхар, (гадна цахилгаан хангамж 15/04 кв-ын КТПН, цэвэр бохир усны, дулааны шугам, холбооны шугам, аюто болон явган зам, хашаа, гаднах бусад тохижилт)	4,579,682,776.00	2023.12.20	146/2023	Хэntий аймгийн Орон нутгийн өмчийн газар, Хэntий аймгийн Биндер сумын Эрүүл мэндийн төв
2	Баян-Өлгий аймгийн Ногооннур сумын Улаан хад баг дахь Эрүүл мэндийн төвийн барилга (Баян-Өлгий аймгийн Ногооннур сумын Улаан хад баг дахь Эрүүл мэндийн төвийн барилга, өөрийн эзэмшилийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй, 5 ортой, зоорлыг, 1 давхар, тэнхлэгээрээ 19.2m*10.0м, 6.0*3.6м Г хэлбэртэй, (гадна цахилгааны КТПН, гадна цэвэр бохир усны шугам цооног, гадна явган зам талбай, гүний худаг, дулаан механик, хашаа бусад тохижилт)	770,356,520.00	2024.07.19	ББКД-83-0005/24	Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газар, Баян-Өлгий аймгийн Ногооннур сумын Улаан хад баг Эрүүл мэндийн төв
			5,350,039,296.00			
		НИЙТ ДҮН	(таван тэрбум түрван зуун тавин сая гучин есөн мянга хоёр зуун ерэн зурага)			